



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 209 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хөрөнгийн биржийн гишүүн компаниудын хавсралтанд дурдсан нэр бүхий ажилтнуудад үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн ҮЦК-иудын ажилтнуудад Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийн үнэмлэх олгох ажил зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн газар /Н.Дөл-Эрдэнэ/-т, арилжааны програмд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т тус тус даалгасугай.
4. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналтын алба /Ж.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР

